



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/483

Арвайхээр

**Ш.Цэвэлсорогдонд буцалтгүй тусламж
олгох тухай**

Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.2, 60 дугаар зүйлийн 60.1 дахь заалт, Засгийн газрын 2019 оны "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох" 7 дугаар тогтоолоор батлагдсан журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь;

1. Нарийнтээл сумын Засаг даргын Тамгын газрын төсөв, төрийн сангийн мэргэжилтнээр ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгох болсон тул Шийлэгдорж овогтой Цэвэлсорогдонд 22.593.068 (хорин хоёр сая таван зуун ерэн гурван мянга жаран найм) төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосугай.

2. Дээрх буцалтгүй тусламжийн 22.593.068 (хорин хоёр сая таван зуун ерэн гурван мянга жаран найм) төгрөгийг орон нутгийн төсвийн тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101489